



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

46083, Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон 304 тоот
Утас: (976) 7053 3539, Вэб сайт: www.audit.mn
И-мэйл: umnugovi@audit.gov.mn

Г ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ ШУДАРГА
ИРГЭДИЙН НЭГДСЭН ЭВСЭЛ НАМД

2020.08.05 № 262

танай _____-ны № _____-т

Хандивын тайлангийн дүгнэлт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намаас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Шударга иргэдийн нэгдсэн эвсэл нам нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6, 25.4.6-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан санхүүгийн тайлангийн маягт, зааврын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар нь Төрийн аудитын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Намаас дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Аудитын дээд байгууллагын Олон улсын стандарт-4000, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/47 тоот тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Улс төрийн намын тухай хуулийн 18

016020292

дугаар зүйлтэй нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж дүгнэлт гаргасан болно.

Дүгнэлт

Шударга иргэдийн нэгдсэн эвсэл намын ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ХОНГОРЗУЛ